

НЭР ДЭВШИГЧ ПҮРЭВСҮРЭН ОВОГТОЙ ДҮҮРИЙМААГИЙН
ОРХОН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2020 ОНЫ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

ИРГЭДИЙН ТӨЛӨӨ “ШИНЭ ХОТ” ХӨТӨЛБӨР

ЗОРИЛГО

Орхон аймгийн иргэдийнхээ ашиг сонирхлыг удирдлага болгож, ардчилал, эрх чөлөөний үзэл санаанд тулгуурлан экологийн чиг баримжаатай улс төр нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгон эрүүл аюулгүй орчинд амьдрах боломжийг бүрдүүлэхэд оршино. Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд:

- Орхон аймгийн залуучуудаа төр засгийн зардлаар дээд боловсрол олгож, нарийн мэргэжил эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх
- Иргэн бүрийн эрүүл мэндийн эмчилгээ, үйлчилгээг төр засгаас бүрэн хариуцаж иргэд эрүүл мэндээ хамгаалуулах эрхээ бүрэн эдлэх,
- Иргэдээ ажлын байраар хангах, орлогын найдвартай эх үүсвэртэй болгох,
- Төр засгийн бүх шатны байгууллагуудыг авлигаас бүрэн цэвэрлэх болно.

Орон нутгийн төр засгийн байгууллага, албан тушаалтнууд хариуцлага хүлээдэггүй өнөөгийн гаж тогтолцоог халж, нутгийн захиргааны шинэ тогтолцоог бий болгоно.

НЭГ. ИРГЭН ТАНЫ АМЬДРАЛД:

Иргэн та нас, хүйс, шашин шүтлэг, намын харъяалал, угсаа гарал, оршин амьдарч буй газар, нийгмийн байр сууриас үл хамааран хүн бүр эрхэм чанараа мөн мэдрэн, айх аюулгүй, эрх чөлөөтэй Эрүүл орчинд амьдран сурч боловсрох эрхтэй. Үүнд:

- Төрийн болон хувийн хэвшлийн салбарт нас, хүйс, зүс царайгаар ялгаварлан гадуурхахыг таслан зогсоох,
- Жирэмсэн эмэгтэйчүүд 3-5 насны хүүхэдтэй ажилчин, ажилтныг ажиллуулж буй аж ахуйн нэгжүүдийг татварын бодлогоор дэмжих,
- Оюунлаг иргэд харилцааг төлөвшүүлэх зорилгоор хүүхэд бүр амьдралын түвшнээс үл хамааран цэцэрлэг, ЕБС, мэргэжлийн болон Их дээд сургуульд суралцах тэгш боломжийг бүрдүүлэх,
- Иргэн бүр дэлхийн стандартад нийцсэн орчин үеийн дэвшилтэд тоног төхөөрөмж, технологи бүхий төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэн эрүүл мэндийн эмчилгээ, үйлчилгээний зардлыг төр засаг бүрэн хариуцдаг тогтолцоог бүрдүүлж эхлүүлэх,

ХОЁР. ӨРХ, ГЭР БҮЛИЙН АМЬДРАЛД:

Монгол Улсын тулгуур баялаг нь “Монгол өрх” мөн тул аймаг сумын төвүүдэд амьдарч буй өрх гэр, залуу гэр бүлүүдийг тохилог орон сууцанд амьдрах бодлогыг боловсруулан өрх бүрийг орон сууцаар хангах зорилт тавьж ажиллана. Үүнд:

- Аймгийн төв сумдад хувийн орон сууц барих бодлогыг дэмжин ажиллах.
- Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих санхүү, зээлийн төвүүдийг дэмжих зэрэг зорилтот бичил банк, санхүүгийн байгууллага байгуулж, хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгосноор айл өрх, аж ахуйн нэгжийн орлого, бизнесийн боломжийг нэмэгдүүлж, ажлын байрыг шинээр бий болгоно.



ГУРАВ. АЙМГИЙН ХҮРЭЭНД:

- Орхон аймгийн агаарын болон хөрсний бохирдол, орчны бохирдол, цагаан тоос, дэд бүтцийн асуудлыг цогцоор шийдвэрлэн цэвэр агаар, эрүүл хөрс, ногоон байгууламж бүхий экологийн тэнцвэртэй орчныг бүрдүүлэх
- Ахмадуудыг төр засгийн байгууллагад сайн дурын зөвлөхөөр авч ажилуулж, ахмад мэргэжилтнүүдийг зохих урамшуулалтайгаар ажиллуулсан ААН-үүдийг татварын тогтолцоогоор урамшуулах
- Орон нутгийн ногоон орчин, гол ус бүхий орчинд иргэдийн оролцоотой байгальд ээлтэй эко хот, аймаг хөтөлбөр хэрэгжүүлэх,
- Иргэд амьдрах таатай эрүүл цэвэр, ногоон технологи бүхий хаягдалгүй орчинг иргэдийн оролцоотойгоор бүрдүүлэх,
- Төр хувийн хэвшлийн оролцоотой хүүхэд, залуучуудын хөгжих орчин нөхцлийг бүрдүүлсэн цэнгэлдэх хүрээлэн, клубууд, урлаг соёлын газрууд, судалгаа шинжилгээ, танин мэдэхүйн үйл ажиллагаа явуулах эрхийг аж ахуйн нэгжүүдэд чөлөөтэй олгох,
- Хөдөө аж ахуйн бүтээгдхүүн, малын гаралтай нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж хөгжүүлэх эрх зүйн өөрчлөлтийг хийх,
- Орон нутгийн удирдлагын чадамжийг дээшлүүлэх, иргэдэд хууль эрх зүй, удирдлагын туслалцаа үзүүлэх, боловсон хүчний асуудал, бүс нутгийн МСҮТ боловсон хүчний сургалт дадлагажилтыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх,
- Хүүхдийн цэцэрлэг, сургуулийн хүрэлцээг нэмэгдүүлэн хүүхдэд ээлтэй ногоон орчин бүрдүүлэх бодлогыг дэмжиж хэрэгжүүлэх,

НЭР ДЭВШИГЧ



П.ДҮҮРИЙМАА

